



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан¹)

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖОЛООЧ СОГТУУ ЭСЭХЭЭ ШАЛГУУЛАХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГТ ХАМРАГДАХ ХУУЛИЙН ШААРДЛАГЫГ БИЕЛҮҮЛЭХ ЁСТОЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаадын ерөнхий харьяаллын нэгдүгээр хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: № 16-1406/2022

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Оросын Холбооны Улсын Ерөнхий харьяаллын нэгдүгээр хяналтын шатны шүүх давж заалдах шатны шүүхэд хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

2021 оны 4 дүгээр сарын нэгэн шөнө Евгений Перепелицын* Chevrolet Lacetti маркийн автомашиныг жолоодож байхдаа жолоодлого алдаж жалга руу унаж осолджээ. Маргааш өглөө нь онхолдсон машиныг Липецк мужийн Грязинск дүүргийн цагдаагийн газрын жижүүр олсон бөгөөд замын цагдаа тус газарт тээврийн хэрэгслийн ослын тэмдэглэл үйлдэх гэж байгаад автомашины эзнийг осол гарсан газраас олжээ. Замын цагдаа Перепелицины жолоодох эрхийг түдгэлзүүлэх тухай тэмдэглэлд “автомашин эзнийг ослын газраас олох үед амнаас нь архи үнэртэж, ганхаж, ойлгомжгүй ярьсан” гэж дурдсан ба Перепелицин замын цагдаад согтуу мэт сэтгэгдэл төрүүлсэн байна. Замын цагдаа автомашины эзнийг согтуу эсэхээ шалгуулж эмнэлгийн үзлэгт орохыг шаардсан боловч Перепелицин татгалзсан² бөгөөд тэрээр ослын дараа согтууруулах ундаа хэрэглэсэнээ үгүйсгээгүй байна.

¹ Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

http://1kas.sudrf.ru/modules.php?name=sud_delo&srv_num=1&name_op=doc&number=17230191&dlo_id=2550001&new=0&text_number=1

² ОХУ-ын Засгийн газрын 2022.10.21- ний өдрийн № 1882 “Согтууруулах ундаа уусан эсэхийг шалгах болон түүний үр дүнг бичих, согтолтын байдлыг тогтоох эрүүл мэндийн үзлэгт явуулах тухай” тогтоолын (Согтууруулах ундаа уусан эсэхийг шалгах болон түүний үр дүнг бичих, согтолтын байдлыг тогтоох эрүүл мэндийн үзлэгт явуулах тухай дүрэмтэй хамт) 8 дахь заалтад заасны дагуу хэрвээ ОХУ-ын цагдаа тээврийн хэрэгслийн жолоочийг согтуу байж болзошгүй гэж таамаглавал, эхлээд жолоочийг согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах тестийг хоолой руу нь үлээлгэж, жолоочийг согтуу эсэхийг шалгадаг. Хэрвээ а) жолооч согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах тестийг хоолой руу нь үлээлгэхээс татгалзсан; б) согтууруулах ундаа



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. Перепелицины дээрх тайлбарт Грязинск шүүхийн тойргийн энх тайвны шүүгч (*анхан шатны шүүх*) итгээгүй бөгөөд шүүгч ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.26 дугаар (*“Тээврийн хэрэгслийн жолооч согтуу эсэхээ шалгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдах шаардлагыг биелүүлээгүй”*)³ зүйлд заасны дагуу зөрчил гаргагч Перепелицины хагас жилийн хугацаанд машин жолоодох эрхийг нь хасаж, түүнд 30 000 рубль торгууль ногдуулжээ.
2. Перепелицын энэ шийдвэрийг Липецк мужийн Грязинск хотын шүүхэд (*давж заалдах шатны шүүх*) давж заалдахад тус шүүх хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Тус шүүхийн үзэж байгаагаар, ослын улмаас зөвхөн осолд буруутай этгээдийн эд хөрөнгө хохирсон, мөн тэрээр ослын талаар замын цагдаад мэдэгдэхгүйгээр осол болсон газрыг орхиж явж болох байсан ба ослын дараа согтууруулах ундаа хэрэглэхийг хэн ч хориглоогүй, мөн цагдаа нарт эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг шаардах хууль зүйн үндэслэл байгаагүй хэмээн Грязинск хотын шүүхийн шийдвэрт дурдсан байна.
3. ОХУ-ын Ерөнхий харьяаллын нэгдүгээр хяналтын шатны шүүхийн орлогч дарга тус шүүх хуралдааны шүүгч Инна Переверзевагийн үзэж байгаагаар 2022 оны 3-р сарын 11-ний өдрийн 16-1406/2022 тоот тогтоолд дурдсанаар машин зогссон эсвэл осол болж өнгөрсөн үеэс үл хамааран замын цагдаагийн ажилтан согтуу хүний гадаад байдлын шинж тэмдгийг олж харсан даруйдаа зөрчил гаргагчийн согтуу байсан эсэхийг тогтоох үүрэгтэй. Мөн тэрээр автомашины жолооч ослын дараа архи уух ёсгүй байсан гэж үзсэн бөгөөд доод шатны буюу Липецк мужийн Грязинск хотын шүүх ОХУ-ын Улсын Дээд Шүүхийн 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 20 дугаар тогтоолын 20 дугаар хэсгийн 10 дахь заалтыг⁴ анхааралдаа аваагүйг дурдсан байна. Тус

хэрэглэсэн эсэхийг шалгах тестийн хариутай санал нийлээгүй; в) тээврийн хэрэгслийн жолооч согтуу байгаа гэж үзэх хангалттай үндэслэлтэй ба согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгах тестийн хариу сөрөг гарсан тохиолдолд; замын цагдаа тээврийн хэрэгслийн жолоочид согтуу эсэхээ шалгуулах эрүүл мэндийн үзлэгт орох шаардлага тавина. URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_429693/ [Сүүлд үзсэн: 2023.04.10]

³ Кодекс Российской Федерации об административных правонарушениях" от 30.12.2001 N 195-ФЗ Статья 12.26. Невыполнение водителем транспортного средства требования о прохождении медицинского освидетельствования на состояние опьянения// (ОХУ-ын 2001 оны 12 сарын 30-ны өдрийн N 195 “Захиргааны зөрчлийн тухай хуулийн” 12.26 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн жолооч согтуу эсэхээ шалгуулах эрүүл мэндийн үзлэгт хамрагдах шаардлагыг биелүүлээгүй) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/ [Сүүлд үзсэн: 2023.04.10]

⁴ Постановление Пленума Верховного Суда РФ от 25.06.2019 N 20 "О некоторых вопросах, возникающих в судебной практике при рассмотрении дел об административных правонарушениях, предусмотренных главой 12 Кодекса Российской Федерации об административных правонарушениях"// (ОХУ-ын Улсын Дээд Шүүхийн Нийт шүүгчдийн



тогтоолд “эрүүл мэндийн үзлэгт хамрагдах хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12.26 дахь зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шийтгэл оногдуулна” гэж заасан байна. Дээрх агуулгаар Ерөнхий харьяаллын нэгдүгээр хяналтын шатны шүүх Грязинск хотын шүүхэд (*давж заалдах шатны шүүх*) хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

Орчуулсан: С. Жансая
Шүүхийн сургалт, судалгаа,
мэдээллийн хүрээлэнгийн
Үндсэн хууль, олон улсын эрх зүйн
судлаач

хуралдааны 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн № 20 “ОХУ-ын Захиргааны зөрчлийн тухай хуулийн 12-р бүлэгт заасан захиргааны зөрчлийн талаарх хэргийг хянан шийдвэрлэхэд шүүхийн практикт үүссэн зарим асуудлын тухай тогтоол”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_327611/ [Сүүлд үзсэн: 2023.04.10]